

## “ХҮҮХЭД ГЭР БҮЛИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН.

2018.06.18

Дархан-Уул

Дархан сумын Хамтарсан багийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуультай нийцэж гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах, харилцан туршлага солилцож багийн “Шилдэг хамтарсан баг”-ийг шалгаруулах зорилготойгоор Дархан сумын ГХУСАЗСЗ, Дархан сумын ЗДТГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Боловсрол, соёл урлагын газаруудтай хамтран “Хүүхэд гэр бүлийн сайн сайхны төлөө хамтдаа” аяныг 2018 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс хүрээнд хийсэн 06 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх 2 сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа. Уг аяны хүрээнд Дархан сумын 1-18-р багуудын Хамтарсан багууд дараах холбогдох мэдээ судалгааг бүрэн шинэчлэн баяжуулж мэдээллийн бааз үүсгэсэн, эргүүл хяналтыг нээлттэй хаалганы өдөрлөгийг хамтран зохион байгуулж иргэд, ААНБ-уудад холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгч мэдээлэл хүргэн ажилласан. Мөн чадвхижуулах сургалтуудад бүх гишүүдийг хамруулахаас гадна 1-18-р багуудын Хамтарсан багийн дарга нарыг туршлага солилцох сургалтанд Сэлэнгэ аймаг руу ГБХЗХГазартай хамтран хамруулсан. Уг аяны хугацаанд үүсэн кейсүүд болон харъяалах нутаг дэвсгэртээ хэрхэн ажилласан тайланг багийн дарааллаар нь нэгтгэн тайлагналаа.



- **Дархан сумын 1-р багийн** Хамтарсан баг Гэмт хэрэг, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй цэгийг тодорхойлон гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлж “САЙН ДУРЫН ЭРГҮҮЛ”-ийг багийн хэмжээнд 5 удаа зохион байгуулж эмзэг цэгүүдэд очиж хяналт тавин зөвлөгөө өгч ажилласан.



- **Дархан сумын 2-р багийн** “Хамтарсан баг” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ААНБ-уудтай хамтран болон хамтарсан багаараа багийн нутаг дэвсгэртээ эргүүл хяналтыг 5 удаа зохион байгуулж гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхэд, согтууруулах ундааны зүйл байнга хэтрүүлэн хэрэглэж орчиндоо болон гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг айл өрхүүдээр орж зөвлөгөө өгч хяналт тавьж ажилласан. Хүүхдийн баярыг тохиолдуулан иргэд ААНБ-уудтай хамтран тус багийн хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхэд, зорилтот бүлгийн 82 хүүхдэд бэлэг гардуулсан. Архины хамааралтай иргэн “Н”-г албадан эмчилгээнд хамруулсан. Ажилласан кейсүүдийг дурьдвал:

1. Аяны үеэр сургууль завсардаж гадуур тэнэдэг гэх сурагч “М” болон “Н” нарын ар гэртэй уулзаж нөхцөл байдлын үнэлгээ хийсэн бөгөөд хүүхэдтэй 4 удаа ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгсний үр дүнд хүүхэд хичээлдээ суух хүсэл нэмэгдэж Насан туршийн боловсролын сургалтанд хамруулсан ба ГБХЗХГазартай хамтран хичээлийн хэрэгсэл дүрэмт хувцасаар хангаж өгсөн.
2. Гэртээ агсам тавьж гэр бүлдээ хүчирхийлэл үйлдсэн гэх “Д” болон “Б” нарын гэрээр орж нөхцөл байдлын үнэлгээ хийж, зөвлөн тусалсан. Мөн түр саатуулах байр /эрүүлжүүлэх байр/-нд 2 удаа очиж “Гэр бүлийн харилцаа, түүнийг хэрхэн хамгаалах вэ?”, “Архи бол өвчин” сэдвүүдээр сургалт, зөвлөгөө хийсэн.



- **Дархан сумын 3-р багийн** Хамтарсан баг гэмт хэрэг, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй цэгийг тодорхойлон гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлж багийн хэмжээнд 5 удаа зохион байгуулж эмзэг цэгүүдэд очиж хяналт тавин зөвлөгөө өгч ажилласан. Хамтарсан багаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн “Б”-гийн гэрээр нь очиж шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулсан.



- **Дархан сумын 4-р багийн** “Хамтарсан баг” нь аяны хүрээнд “Хүүхдийн утас 108” дугаарт ирсэн 2 дуудлага мэдээлэлийн дагуу үл хайхрагдах хүчирхийлэлд өртсөн “Т”, “Б” нарын эцэг эхтэй уулзаж Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг танилцуулан зөвлөгөө өгч НБҮ хийсэн ба холбон зуучлах үйлчилгээ үзүүлж, эцэг архины хамааралтай “Ц”-тэй ганцаарчлан уулзаж ярилцан архины эмчилгээнд хамруулсан. “Т”-гийн ар гэрийн нөхцөл байдлын талаар тодруулан, хүүгийн эх архины хамааралтай “Э” -тэй уулзаж НБҮ хийн, байрны оршин суугчидтай уулзаж тодруулга ажиллаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 1, орц хонгилд хамьдарч байгаа 4 хүүхдэд “Хүүхдийн баяр”-аар бэлэг өглөө. Мөн хөгжлийн бэрхшээлтэй охин Б.Мичидийг 7-р цэцэрлэгийн “Тэмүүлэл” бүлэгт хамруулан, “Кама сервис” ОУБ-тай хамтарч жингийн алдагдалтай хүүхдүүдийг өөрийн жиндээ хүртэлх хугацаанд нь витаминжуулахаар боллоо.



- **Дархан сумын 5-р багийн** “Хамтарсан баг” нь “Хүүхэд гэр бүлийн сайн сайхны төлөө хамтдаа” аяны хүрээнд “Амгалан өрх” өдөрлөгийг 2018 оны 05 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулж тус багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага Цагдаагийн газар, Сум дундын шүүх, Прокурорын газар, ХГБЗХГ, ХХҮГ, Хөгжлийн төв, Ниймгийн даатгалын газар, ЭМГ, 15-р сургууль, Жигүүр цогцолбор, 25-р цэцэрлэг, МСҮТөв зэрэг байгууллагууд оролцов. Арга хэмжээнд багийн 120 гаруй иргэн оролцож өөрсдийн уулзахыг хүссэн төрийн байгууллагуудтай уулзаж зөвлөгөө мэдээлэл авсан. Архины хамааралтай иргэн “Ц”, “Э” нарыг архины албадан эмчилгээнд хамруулав. Далд хэлбэрийн гэр бүлийн хүчирхийлэлийн талаар 2 иргэн ганцаарчилсан зөвлөгөө авч асуудлаа шийдвэрлүүлэхээр холбогдох

байгууллагад нь зуулчилж өглөө. Иргэн “Ш” нь гэртээ согтуугаар 3 хүүхдээ зодож хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэг гарч хамтарсан баг шуурхай ажиллаж 3 хүүхдийг эмнэлэгт хүргэж яаралтай эмнэлэгийн тусламж авахуулж цагдаагийн байгууллагад шилжүүлэн хуулийн дагуу хариуцлага хүлээсэн. Эхнэр Одончимэг 3 хүүхдэд байнгын хяналт тавьж тусламж дэмжлэгт хамруулан ажиллаж байна. Мөн архины хамааралтай гэр бүл болох Г.Дархансанчирын гэр бүлийг “Шинэ амьдралын дуудлага” төрийн бус байгууллагад хүсэлт гаргаж зан үйлийн нөлөөлөлийн сургалт, архинаас гаргах сургалт, өрхийг дэмжих сургалтанд үе шаттайгаар хамруулан ажиллаж байна.



**Дархан сумын 6-р багийн “Хамтарсан баг”** нь өргөтгөсөн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв.

1. Тээвэрчид 7 гудамж 10 тоотод ам бүл 8-уулаа амьдардаг /6 хүүхэдтэй/ охин Ш нь гэр бүлийн үл хайхрах хүчирхийлэлд өртдөг, гадуур худлаа ярьж тэнэдэг, хоногоор алга болдог. Охины төрсөн эцэг Б болон эмээ Н, охин Ш нарыг байлцуулан хуралдаж охин Ш-ийг албан ёсоор асран хамгаалагч эцэг Б-д шүүхийн шийдвэр гартал хүлээлгэн өгсөн. Цаашид сэтгэл зүйн зөвөлгөө авахуулах, нөлөөллийн сургалтанд хамруулан ажиллаж байна.
2. Тээвэрчид 14 гудамж 2 тоотод ам бүл 4-үүлээ амьдардаг /2 хүүхэдтэй/ Д.Х нар нь гэр бүлийн хүчирхийлэлтэй, гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг цагдаагийн хэсгийн байцаагчид өргөдөл өгсний дагуу тухайн өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийн, хамтарсан багийн гишүүд хуралдан зөвөлгөө өгөн ажилласан. Цаашид сэтгэл зүйн зөвөлгөө авахуулах, нөлөөллийн сургалтанд хамруулсан.
3. Ханжаргалан 2 гудамж 16 тоотод 8-13 насны 3 хүүхэдтэй 5 ам бүлтэй Ц.Н, эхнэр Б.Б нар нь архины хамааралтай, Н нь согтуудаа эхнэрийгээ зоддог. Гэрт нь нөхцөл байдлын үнэлгээ хийн, хамтарсан багийн гишүүд хуралдан ГБХЗХГ-ын хуулийн зөвлөхөөр зөвөлгөө өгүүлэн ажилласан.
4. Аймгийн Хууль зүйн хэлтэс, Цагдаагийн газраас зохион байгуулсан архины албадан эмчилгээнд 3 иргэнийг Шар хадны эмнэлэг рүү явуулсан. 3 иргэний ар гэрээр эргүүлээр хэсгийн байцаагч Аз жаргалын эрэлд ТББ-ын тэргүүн Ц.Оюунчимэг нартай хамтарч зөвөлгөө өгч уулзан цаашид төлөвлөгөө гарган ажиллаж байна.
5. Тээвэрчдийн задгайд оршин суудаг С нь архины хамааралтай, охин Э нь 1 хоногоор алга болж цагдаагийн бүрэлдэхүүнтэй эрэн сурвалжилж олсон. Хамтарсан баг хуралдаж, эргүүлээр өдөр бүр очин охин Э-г эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан ажиллаж байна.

- **Дархан сумын 7-р багийн “Хамтарсан баг”** нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ААНБ-уудтай хамтран болон хамтарсан багаараа багийн нутаг

дэвсгэртээ эргүүл хяналтыг 5 удаа зохион байгуулж гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхэд, согтууруулах ундааны зүйл байнга хэтрүүлэн хэрэглэж орчиндоо болон гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг айл өрхүүдээр орж зөвлөгөө өгч хяналт тавьж ажилласан.

1. Өөрийн гэсэн гэр оронгүй ахтайгаа маргалдаж гэрээсээ хөөгдсөн гэх хөгжлийн бэрхшээлтэй иргэн “Н” нь 1 настай хүүхэдтэйгээ ээжийнхээ дүүгийн амьдардаг. Хамтарсан багаар хуралдаж сэтгэл зүйн зөвлөгөө өгч, ах “С”-нд түр байлгах асуудлыг шийдвэрлэсэн.

2. Иргэн “А”, “Ч” нар нь 3-12 насны 2 хүүхэдтэй бөгөөд эхнэр “А” нь гадуур их тэнэдэг, нөхөрийгөө ажилд явсан үед нь 2 хүүхдээ гэртээ орхиод 2-3 хоногоор алга болж хүүхдийг үл хайхарсан. Хамтарсан багаар хуралдаж эхнэр нөхөр 2-т сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлж, гэрт нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийж багийн Нийгмийн ажилтан 7 хоногт 3 удаа эргэлтээр очиж уулзалт хийж хяналт тавина ажиллаж байна.

3. “А” нь 8 настай хөгжлийн бэрхшээлтэй зорилтод бүлгийн хүүхэд бөгөөд хүргэн ах “Э” нь архидан согтуурсан үедээ зодож хүүхдийн биед гэмтэл учруулсан байсныг Хамтарсан багаар хуралдаж Нийгмийн ажилтан, Хэсгийн байцаагч, Хүүхдийн байцаагч нар нэг цэгийн үйлчилгээнд хамруулж эмчилгээ хийлгэсэн. Шүүх эмнэлэгт үзүүлж гэмтлийн зэрэг тогтоолгоход хөнгөн гэмтэл гэж гарсан. Хүүхэд айж цочирдсон байсан тул сэтгэл заслын эмчилгээнд хамруулж байнгын хяналт тавина ажиллаж байна.

4. Эцэг эхийн үл хайхрах хүчирхийлэлд өртсөн гэх зорилтод өрхийн хүүхэд болох “П”-г Хамтарсан багийн хурлаар хэд хэдэн удаа хэлэлцлэгдсэн. Байнгын хяналтанд, хөршийн холбоог ажлуулж байгаа.

5. Хойд аав “Б” нь дагавар охин “О”-г дүүтэйгээ аяга таваг булаацалдлаа гэж зодсон ба гадуур хувцасаараа ороологосны улмаа охины баруун хөмсөг шалбарч хавдсан байдалтай байсныг хэлэлцэж “Б”, “Н” нарыг сэтгэл зүйчтэй уулзуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлэх, хүүхэд болон эцэг эхэд хяналтыг тавих, зан төлөвшлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



- **Дархан сумын 8-р багийн “Хамтарсан баг”** нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ААНБ-уудтай хамтран болон хамтарсан багаараа багийн нутаг дэвсгэртээ эргүүл хяналтыг 3 удаа зохион байгуулж гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүүхэд, согтууруулах ундааны зүйл байнга хэтрүүлэн хэрэглэж орчиндоо болон гэр бүлдээ түгшүүр төрүүлдэг айл өрхүүдээр орж зөвлөгөө өгч хяналт тавьж ажилласан.

17-р хороолол 4-р барйны 31 тоотын иргэн А-г гэртээ хууль бусаар архи найруулан худалдан борлуулдаг байсныг илрүүлэн зөрчлийн тухай хуулиар 50.000 төгрөгөөр торгон сануулга өглөө. 7-р байрны 8 тоотод оршин суугч Х.Ц нь гэр бүлдээ архи уусны улмаас агсан согтуу тависны улмаас эхнэр Р.Ц нь 102-т дуудлага өгсөн. Дуудлагын дагуу хамтарсан багаар хуралдаж гэр бүлд нь зөвлөгөө өгч гэр бүлийн

болон зөрчлийн тухай хуулийн зөвөлгөө өгч дахин гэр бүлдээ агсан согтуу тавихгүй байх тал дээр хяналт тавин ажиллаж байна. 17-р хороолол 4-р барьны 31 тоотын иргэн А-г гэртээ хууль бусаар архи найруулан худалдан борлуулдаг байсныг илрүүлэн зөрчлийн тухай хуулиар 50.000 төгрөгөөр торгон сануулга өгч ажиллаа.

- **Дархан сумын 10-р багийн** “Хамтарсан баг” нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл хяналтыг зохион байгуулж БЗДарга, Нийгмийн ажилтан нар багийн нутаг дэвсгэр дэх зоорийн давхарт амьдардаг 13 өрхөөр орж судалгаа гарган Гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн талаар хууль сурталчлан ажиллаа. Мөн тус аяны хүрээнд “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй зоорийн давхарт амьдардаг 13 өрхийн 34 хүүхдэд багийн захиргаа иргэн А.Ариунаатай хамтран 5-3-7-р орцны П.Баярмаа, 5-4-1-р орцны Э.Уянга нарын 4 хүүхдэд баярын бэлэг болон иж бүрэн хувцас бусад 31 хүүхдэд баярын бэлгийг гэрээр нь болон СӨХ-дээр нь цуглуулан гардуулан өгч сэтгэлийн бэлэг барьлаа.



- **Дархан сумын 13-р багийн** “Хамтарсан баг” нь аяны хугацаанд 10-р хорооллын 13-р байрны 21 тоотод оршин суугч иргэн “Б” нь нөхөр “А”-гийн хүчирхийлэлд өртөн зодуулж гэмтсэн гэх гомдлын мөрөөр ажиллалаа. Хэсгийн байцаагч Аюулгүйн зэргийн үнэлгээ хийхэд 12 оноо буюу эрсдлийн түвшин дунд зэрэг гэж гарсан. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хохирогч “Б” болон “А” нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

- **Дархан сумын 15-р багийн** “Хамтарсан баг” нь аяны хугацаанд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэх “Г” -д холбогдох кейс дээр ажиллалаа. Охины төрсөн эцэг “Г” хүчирхийлэгч нь гэсэн мэдээллээр хүүхдийг нэг цэгийн үйлчилгээнд хамруулсны дараа гэмтлийн эмнэлэгт 10 хоносон. 06-р сарын 13-нд хүүхдийн байцаагч, ГБХЗХГ-ын мэргэжилтэн, багийн нийгмийн ажилтан нар хамтран Улаанбаатар хот дахь хүүхдийн түр хамгаалах байранд хэргийг хуулийн дагуу шийдвэр гаргал хүлээлгэн өгсөн.



- **Дархан сумын 16-р багийн** “Хамтарсан баг” нь аяны хугацаанд 2 кейс дээр ажилласан.

1. “Б” нь 25 жил хориход ял эдэлж байгаад 2017 оны 7 сард суллагдан гарсан ба иргэн “Т”-тэй хамтран амьдарч өөрийн хүүхэдтэй болсон. Энэ хугацаанд гэр бүлдээ байнга хүчирхийлэл дарамтзүүлж зодох, заналхийлэх зэргээр хүчирхийллийн бүхий л хэлбэрийг үйлддэг байв. Аюулын зэргийн үнэлгээ хийхэд эрсдлийн түвшин 12 гарсан тул “Б”-гийн хохирогч “Т” болон дагавар охин “Э” нартай уулзах эрхийг хязгаарлан тусгаарлах арга хэмжээг авсан.

2. “З”, “А” нарын хоорондын үл ойлголцолоос болж нөхөр “А” нь эхнэртээ гар хүрсэн тул ГБХТХууль эрх зүйн зөвлөгөө, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг танилцуулж “З”, “А” нарыг сэтгэл зүйчтэй холбон зуучилж өгөхөөр шийдвэрлэсэн.

Тайлан нэгтгэсэн: БХНАХМ

/С.ДАРЬЦЭЦЭГ/

